

ТАНИЛЦУУЛГА

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн мэдээллийн сайн дурын бүртгэл хөтлөх журмын талаар

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Оюуны өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч, хамаарах эрх эзэмшигчийн хүсэлтээр зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн бүтээлийн сайн дурын үндсэн дээр бүртгэх, гэрчилгээ олгох, журмыг *оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан*.

Оюуны өмчийн тухай хуулийн дээрх зохицуулалтыг үндэслэн “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн бүтээлийг сайн дурын үндсэн дээр бүртгэх, гэрчилгээ олгох журам”-ын төслийг боловсруулав.

Журмын төслийг боловсруулахдаа өмнө нь дагаж мөрдөж байсан журмыг үндэслэн Оюуны өмчийн тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хуулинд нийцүүлсэн болно.

Журмын төсөлд зохиогчийн эрхийн бүтээлийн мэдүүлэг гаргах, мэдүүлэгт тусгах мэдээлэл, хавсаргах баримт бичиг, мэдүүлгийг хүлээн авах, бүтээлийг бүртгэх, гэрчилгээ олгох шийдвэр гаргах болон олгогдох гэрчилгээнд тавигдах шаардлагын нь талаарх зохицуулалтыг тусгав.

Журмын төсөл батлагдсанаар Иргэн, хуулийн этгээдийн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн бүтээлийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд сайн дураар бүртгэх, бүртгэснийг нотолж зохиогчийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулах журамтай болно. Гэрчилгээ олгосноор зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, тэдний бүтээн туурвих үйл ажиллагааг дэмжих, лиценз, франчайз, мерчандайзийн болон бусад гэрээ, хэлцлээр бусдад зохиол бүтээлээ бүрэн болон хэсэгчлэн ашиглуулах, өмчлөх эрх шилжүүлэх, оюуны өмчөөр хуулийн этгээдэд хөрөнгө оруулах, барьцаалах болон бусад хэлбэрээр эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг хэрэгжүүлэхэд нотлох, бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих ач холбогдолтой болно.